



ЭРГЭН МЭДЭЭЭЛЭЛ

2026 ОНЫ II УЛИРАЛ



77117444-1




tandalt@gemtel.moh.gov.mn



www.gemtel.mn


МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ 2026 II УЛИРАЛ




2026 оны эхний 6 сарын хугацаанд Монгол Улсын хэмжээнд гэмтэл хордлого, гаднын шалтгаант 120804 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 10.5%-иар өссөн үзүүлэлттэй байна.



Осол гэмтэлд өртсөн тохиолдлын 59.4% (71749) нь эрэгтэй, 40.6% (49055) нь эмэгтэй байна. Өөрөөр хэлбэл осол гэмтлийн шалтгаант 10 шинэ тохиолдол тутмын 5-6 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй байна.



Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх, хувиар




- Согтууруулах ундаа хэрэглэсэн
- Согтууруулах ундаа хэрэглэсэн

Нийт тохиолдлын 11.3% (13670) нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртсөн байна.




2026 оны эхний 6 сард бүртгэгдсэн нийт осол гэмтлийн тохиолдлын 13.0% (15698) 10-14 насны хүүхэд байна. 39.3% (47472) нь 0-18 насны хүүхэд байгаа бөгөөд



2026 оны эхний 6 сард бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант тохиолдлын 40.5% (48941) нь зөвхөн уналтын шалтгаант осол гэмтэл байна. Мөн амьгүй механик хүчинд өртөх 19.5%, зам тээврийн осол 12.2%, амьд механик хүчинд өртөх 9.4% байгаа нь тэргүүлэх шалтгаан болж байна.


ICD10	Осол гэмтлийн шалтгаан	Нийт	Хувь
W00-W19	Уналт	48941	40.5
W20-W49	Амьгүй механик хүчинд өртөх	23565	19.5
V01-V99	Зам тээврийн осол	14748	12.2
W50-W64	Амьд механик хүчинд өртөх	11300	9.4
X85-Y09	Хүчирхийлэл	9814	8.1
W85-X19	Түлэгдэлт	3729	3.1
X40-X49	Санамсаргүй хордох, хорт бодист өртөх	3057	2.5
Y10-Y34	Тодорхойгүй осол	2667	2.2
X50-X59, Y35-Y98	Бусад осол	1232	1.0
X60-X84	Санаатайгаар өөртөө гэмтэл учруулах	868	0.7
X30-X39	Байгалийн хүчинд өртөх	666	0.6
W75-W84	Амьсгал боогдох	148	0.1
X20-X29	Хорт амьтан ургамалд өртөх	37	0.03
W65-W74	Усанд унаж живэх	32	0.03

Осол гэмтэлд өртөх үеийн байршлаар харвал гудам, зам (33.0%) мөн гэртээ (31.3%) гэмтэх тохиолдол өндөр байна.



2026 оны эхний 6 сард бүртгэгдсэн осол гэмтлийн нийт тохиолдлын 17.6% (21293) орон нутагт бүртгэгдэж тохиолдлын тоогоор Өвөрхангай, Сэлэнгэ, Дорнод, Дорноговь, Дархан-Уул аймгууд тэргүүлж байгаа бол 82.4% (99511) нийслэл Улаанбаатар хотод бүртгэгджээ. Харин нийслэлд бүртгэгдсэн тохиолдлын 92.7% (92285) ГССҮТөвийн ЯТТасгаас тусламж үйлчилгээ авчээ.



Осол гэмтлийн шалтгаант шинэ тохиолдол



МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ 2026 II УЛИРАЛ

Монгол улсын хэмжээнд 2026 оны эхний 6 сарын байдлаар осол гэмтлийн шалтгаант 1554 нас баралт бүртгэгдсэн байна.


Осол гэмтлийн шалтгаант нас баралт




Нийт тохиолдлын 77.4% (1203) нь эрэгтэйчүүд, 22.6% (351) нь эмэгтэйчүүд байна.

2026 оны эхний 6 сарын байдлаар осол гэмтлийн шалтгаант нас баралт 40-54 насанд хамгийн өндөр хувийг эзэлж байна.


Осол гэмтлийн шалтгаант нас баралт, насны бүлгээр



Нийт тохиолдлын 56.2% (874) нь гэмтэх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн байна.



2026 оны эхний 6 сарын байдлаар бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралт 3-р сард хамгийн өндөр буюу 350 тохиолдол бүртгэгдсэн байна.



ОСОЛ ГЭМТЛИЙН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН:

1. Санамсаргүй хордох 35.1% (n=546)
2. Зам тээврийн осол 16.7% (n=260)
3. Амиа хорлох 16.3% (n=254)
4. Байгалийн хүчинд өртөх 8.2% (n=127)
5. Хүчирхийлэл 6.1% (n=95)

ӨОУА-10	Осол гэмтлийн шалтгаан	Бодит тоо	Эзлэх хувь
Санамсаргүй осол гэмтэл			
X40-X49	Санамсаргүй хордох	546	35.1
V01-V99	Зам тээврийн осол	260	16.7
X30-X39	Байгалийн хүчинд өртөх	127	8.2
W00-W19	Уналт	94	6.1
W75-W84	Амьсгал боогдох	51	3.3
Y10-Y34	Тодорхойгүй осол	46	3
W65-W74	Усанд живэх	30	1.9
W85-X19	Түлэгдэлт	23	1.5
W20-W49	Амьгүй механик хүчинд өртөх	20	1.3
W50-W64	Амьтай механик хүчинд өртөх	7	0.5
Санаатай үйлдлээс үүдсэн осол гэмтэл			
X60-X84	Амиа хорлох	254	16.3
X85-Y09	Хүчирхийлэл	95	6.1

2026 оны эхний 6 сарын байдлаар осол гэмтлийн шалтгаант нас баралтын 51.3% (797) нийслэлд бүртгэгдсэн бол 48.7% (757) нь орон нутагт бүртгэгдсэн байна.



Нийслэл – 51.3%



Орон нутаг – 48.7%

21 аймагт бүртгэгдсэн нар баралтыг харвал баруун бүсийн аймгуудаас Баян-Өлгий, Увс аймагт, хангайн бүсээс Өвөрхангай, Хөвсгөл аймагт, зүүн бүсээс Хэнтий аймагт, төвийн бүсээс Дорноговь болон Дорноговь аймагт их тохиолдсон байна.

Бүртгэгдсэн газар	Тохиолдлын тоо	Хувь
Баруун бүс	129	8.3
Баян-Өлгий	30	1.9
Говь-Алтай	20	1.3
Завхан	28	1.8
Увс	29	1.9
Ховд	22	1.4
Хангайн бүс	276	17.7
Архангай	53	3.4
Баянхонгор	26	1.7
Булган	34	2.2
Өвөрхангай	56	3.6
Хөвсгөл	55	3.5
Орхон	52	3.4
Зүүн бүс	88	5.7
Дорнод	31	2.0
Сүхбаатар	16	1.0
Хэнтий	41	2.6
Төвийн бүс	264	16.9
Говьсүмбэр	10	0.6
Дархан-Уул	22	1.4
Дорноговь	53	3.4
Дундговь	24	1.5
Өмнөговь	41	2.6
Сэлэнгэ	68	4.4
Төв	46	3.0
Орон нутгийн дүн	757	48.7
Улаанбаатар	797	51.3
Улсын дүн	1554	100